

**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар сарын 15

Улаанбаатар хот

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал/	Тасарсан болон удааширч буй шалтгаан
1	2	3	4	5	6
САЛБАР ЧИГЛЭЛ: 1					
1. Монгол Улсын хууль					
1.1	№1	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2021.07.02 №1	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуулийн 19.1 зүйлд заасан “тэтгэмж авах эрх үүссэн ихэр хүүхэд төрүүлсэн эхэд тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувиар тооцож 4 сар 20 хоногийн хугацаанд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно” гэсэн өөрчлөлтийн дагуу хэрэгжилтийг ханган, иргэд даатгуулагчдад сурталчлан ажиллаа. Тайлант хугацаанд нийслэлийн хэмжээнд 99 даатгуулагч эхэд 250,3 сая төгрөгийн тэтгэмжийг хугацаанд нь олгосон байна. /100/		
1.2		Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн	Хөдөлмөрийн тухай хууль 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шинэчлэн батлагдан мөрдөж эхэлснээр хэлтсийн Хөдөлмөрийн дотоод журам, бусад холбогдох журмуудыг Хөдөлмөрийн тухай хууль болон Төрийн албаны тухай хууль бусад дагалдах дүрэм, журмын хүрээнд хэлтсийн даргын		

		найруулга 2021.07.02	тушаалаар шинэчилсэн. Төрийн үйлчилгээний албан хаагчидтай байгуулах хөдөлмөрийн гэрээг шинэ хуулийн дагуу байгуулан ажиллаж байна. Тушаал шийдвэрийг Хөдөлмөрийн тухай хууль болон Төрийн албаны тухай хууль бусад дагалдах дүрэм, журмын хүрээнд боловсруулан мөрдөн ажиллаж байна./100/		
1.3		Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/ 2021.12.17	Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах ажлыг зохион байгууллаа. Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд нь нүүр унших төхөөрөмж суурьлуулан ажилтан албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг бүртгэж байна. /100/		
Хэсгийн дундаж: 100 хувь					
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг					
2.1		Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай. 2022.07.11	Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2022 оны долдугаар сарын 11-ний өдөр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залах тухай 159 дүгээр зарлигийг гаргасан билээ. Уг зарлигийн хоёрдугаар зүйлд “Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай” гэж заасан. Тус зарлигийн дагуу Нийслэлийн нийгмийн даатгалын газар болон дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүд Их эзэн Чингис хааны эш хөргийг хүндэтгэн, дээдлэн заллаа. /80/		Багахангай, Хан-Уул дүүргийн хэлтсүүд одоогоор Эзэн Богд Чингис хааны эш хөргийг залаагүй байна.
Хэсгийн дундаж: 80 хувь					
3. Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар					
3.1	№03	Цахим шилжилтийг	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны А/62 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын архивын ажлын заавар”-т заасны дагуу иргэд,		

		эрчимжүүлэх тухай 2022.07.04 №03	даатгуулагчид үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэж, хэлтсүүд хооронд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн архивын лавлагааг ажлын 3 хоног дотор солилцох ажлыг зохион байгуулж хэвшсэн. 2006 оноос хойших лавлагааг local.ndaatgal.mn программаас олгодог болсноор иргэдийн цаг, хугацааг хэмнэж байна. Нийт дүүргүүдийн хэмжээнд архивын лавлагаа авах 48979 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнд: Цаасан баримтаас шүүсэн-7750, Бусад аймаг, дүүргийн хэлтэст уламжилсан, хэлтсүүдээс хүсэлт ирүүлсэн 6146, < http://local.ndaatgal.mn/ > программаас олгосон QR кодтой лавлагаа 234010, < http://app.ndaatgal.mn/ > нэгдсэн сүлжээний лавлагаа 1073 тус тус олгосон байна. Нийгмийн даатгалын шинэчлэлийг эрчимтэй хийж 2022 оны байдлаар нийгмийн даатгалын 34 үйлчилгээний 24 үйлчилгээг цахимжуулж, 12 үйлчилгээг төрийн үйлчилгээний E-Mongolia цахим сүлжээнд холбогдсон байна. /100/		
Хэсгийн дундаж: 100 хувь					
4. Засгийн газрын тогтоол					
4.1.	№362	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журам 2021.12.01 №362	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хугацаа, олгох журамтай танилцлаа. Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тэтгэврийг давхардуулан олгохгүй байх, иргэдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор тэтгэвэр тогтоолгох иргэдэд зөвлөгөө мэдээллийг тухай бүр өгч, сургалт сурталчилгаа зохион байгуулан ажиллаж байна. /100/		
4.2.	№374	Тогтоолын хавсралтад нэмэлт	"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай" Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолд 2021 оны 374 тоот Засгийн газрын тогтоолоор нэмэлт		Найруулгын алдаатай, үсгийн

		<p>өөрчлөлт оруулах тухай 2021.12.14 №374</p>	<p>өөрчлөлт оруулсан. Уг тогтоолын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, нэгтгэн хуулийн хугацаанд дээд шатны байгууллагаар баталгаажуулан ажилласан.</p> <p>Уг тогтоолын хэрэгжилтийг бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг дээд газруудад тайлагнахдаа мөрдлөг болгон ажиллаж байна. /90/</p>		<p>фонт, хэмжээ өөр өөрөөр бичих</p>
4.3.	№388	<p>Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2021.12.22 №388</p>	<p>Нийслэлийн Нийгмийн даатгалын газар, хэлтсүүд нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/22 дугаар тушаалын дагуу нийт 433 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаас 2022 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 423 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Удирдах албан тушаалтан 10 ➤ Гүйцэтгэх албан тушаалтан 378 <p>Төсвийн байгууллагын үйлчилгээний ажилтан 35 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Орон тооны цомхотгол хийхгүй байх, одоо ажиллаж байгаа ажилчдыг үндсэн ажилтнаар шилжүүлэн ажиллуулах, ажилчдын цалин хөлс, урамшуулал, тэтгэвэрт гарахад нь хуульд заасны дагуу олгох нэг удаагийн тэтгэмжийг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байхаар төсвийн төсөл, төсөөлөлд тусган саналаа хүргүүлэн ажиллаж байна. /100/</p>		
4.4.	№1	<p>Журам шинэчлэн батлах тухай 2022.01.05 №1</p>	<p>Коронавирус цар тахлын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт албан хаагчдад маск амны хаалт, спирт, гар ариутгагч тарааж, иргэд, ажилтан албан хаагчдыг эрсдэлээс хамгаалах зорилгоор өрөө тасалгаануудыг тогтмол цэвэрлэж ариутгаж байна. Ковид-19 вирусээс урьдчилан сэргийлэх эрсдэлийг эрт илрүүлэх ухаалаг утсанд суурилсан “КОВИД-19 ЭРСДЭЛ” системийг нийт албан хаагчдын утсанд суулгаж байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл зөвлөгөө хүргэж ажиллаа. Энэхүү системийг суулгаж идэвхжүүлснээр 15 минутаас дээш хамт байсан хүмүүсээс хэн нэгний PCR шинжилгээ эерэг гэсэн хариу гарахад 1-р хавьтагч гэдэг мэдээлэл утсанд нь очих бөгөөд ингэснээр халдварт өртсөн эрсдэлээ цаг алдахгүй</p>		

			мэдэх, эрт илрүүлэх учирч болох аливаа эрсдэлээс өөрийгөө бүрэн хамгаалах давуу талтай юм. /100/		
4.5.	№63	Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай 2022.02.01 №63	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйл, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасныг үндэслэн нийгмийн даатгалын сангаас олгож байгаа байгаа болон цэргийн албан хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500000 /таван зуун мянган/ төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400000 /дөрвөн зуун мянган/ төгрөгөөр нэмэгдүүлсэн. Нийслэлийн хэмжээнд 200336 тэтгэвэр авагчийн тэтгэвэр сард 28,1 тэрбум төгрөгөөр буюу 2022 онд 309,1 тэрбум төгрөгөөр тэтгэврийн хэмжээ нэмэгдэж 2022 онд нийт тэтгэвэр авагчдад 1554,0 тэрбум төгрөгний тэтгэврийг цаг хугацаанд олгосон болно. /100/		
4.6.	№7	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.01.05 №7	“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус хэлтсийн албан хаагчдын эх хэлний боловсролын мэдлэг, чанар хэрэглээг дээшлүүлэх, төрийн албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах зорилтыг хэрэгжүүлэн ажилласан. Нийслэлийн нийгмийн даатгалын газар болон дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч албан хаагч нар НДЕГ-аас 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн зохион байгуулагдсан цахим сургалтад хамрагдаж үндэсний монгол бичгээр албан бичиг төлөвлөх, боловсруулах ур чадвар эзэмшин, гэрчилгээ авч, бусад албан хаагчдад сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. /95/		Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагын ажилтан, албан хаагч нар монгол бичгийн хичээлд хамрагдсан хэдий ч монгол бичгээр албан бичиг төлөвлөх, бичих тал дээр дулимаг байна.
4.7.	№107	Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан	Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд нь 2022 оны батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107,192 дугаар тогтоолыг үндэслэн ТҮ-ээр цалинжин		

		хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай 2022.03.09 №107	ажиллаж байгаа ажилтан, албан хаагчийн цалинг шинэчлэн тогтоосон болно. /100/		
4.8.	№187	Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах хэмжээний тухай 2022.05.11. №187	Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс нийгмийн даатгалын байгууллагуудад 406 өргөдөл, гомдол ирсэн байна. Нийт ирсэн гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэсэн бөгөөд хуулийн хугацаанд нь 402 өргөдлийн шийдвэрлэн ажилласан байна. 4 өргөдлийг судлан шийдвэрлэхээр ажиллаж байна. Нийт шийдвэрлэлтийн дундаж хувь 99 хувьтай ажилласан байна. /99/		ЗГ-ын 11-11 төвд ирсэн өргөдөл, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэж байна. Одоогийн байдлаар 4 өргөдлийг шийдвэрлэхээр судалж байгаа бөгөөд шийдвэрлэлтийн хувь 99 хувь.
4.9.	№204	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.05.25 №204	Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд нь автомашины хэрэглээг хязгаарлаж холбогдох мэдээ, мэдээлэл, тооцоо судалгааг дээд шатны байгууллага руу хүргүүлсэн болно. /100/		
4.10.	№192	Тогтоол, тогтоолын хавсралтад	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн		

		<p>өөрчлөлт оруулах тухай 2022.05.11 №192</p>	<p>шинээр төрийн захиргааны албан хаагчийн цалинг, 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрөөс 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолын долдугаар хавсралтаар батлагдсаны дагуу төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдсон албан хаагчдын цалинг нэмэгдүүлэн олгосон.</p> <p>Мөн тогтоолын долдугаар хавсралтаар “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ"-г тогтоож өгсөн бөгөөд 2022 оны “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 192 тоот тогтоолыг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний албан тушаалд шинээр томилогдох албан хаагчдын цалинг шинэчлэн олгож байна. /100/</p>		
4.11.	№201	<p>Журам батлах тухай 2022.05.18 №201</p>	<p>Төрийн байгууллагын вэб сайтад тавигдах шаардлага MNS6285:2017 стандартыг баримтлан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/108 дугаар тушаалаар “ndaatgal.mn” цахим хуудсыг шинэчлэх ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд зөвхөн http://www.ndaatgal.mn вэбсайтад холбогдсон холбоосоор дамжин салбарын хэмжээнд нэгдсэн чиглэлийн дагуу хөтлөж ажиллуулах үүрэг өгөгдсөн.</p> <p>Нийслэлийн нийгмийн даатгалын газар болон дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүд нь энэхүү үүрэг даалгаврын дагуу <https://xxx.ndaatgal.mn/> вэб сайтын хөгжүүлэлтийг шинэчлэн хөтлөж мэдээлэл оруулах, шинэчлэх ажлыг цаг тухай бүр хийж хэрэгжүүлж байна. Мөн цаг үеийн мэдээлэл, нийгмийн даатгалын ажил үйлчилгээтэй холбоотой видео контент, иргэд даатгуулагчдад шаардлагатай бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, дансны жагсаалт зэргийг оруулсан болно. /100/</p>		
4.12.	№266	<p>Дүрэм шинэчлэн батлах тухай</p>	<p>Гомдлын шаардлагын зөвлөлд ирсэн 2 гомдлыг хүлээн авч зөвлөл хуралдаж асуудлыг шийдвэрлэн тогтоол гарсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Гомдлын шаардлагын зөвлөлд тайлан мэдээг хүргүүлэн ажилласан.</p>		

		2022.07.05 №266	Мөн цаг үеийн холбогдолтой удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж ажиллаа. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр шинээр батлагсан “Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм”-ийн дагуу Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2022 оны А/132 дугаар тушаалаар дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтэс бүрэлдэхүүнээ шинэчлэн баталсан. /100/		
Хэсгийн дундаж: 98,6 хувь					
5. Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
5.1.	№28	Тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллах 2022.05.11 №28	Цахим гарын үсгийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан, НДЕГ-ын даргын 2022 оны А/130 тушаалаар баталсан “Е-токен төхөөрөмж ашиглах заавар”-ыг хэрэгжүүлэн ажиллаж, нийслэлийн хэмжээнд 410 албан хаагчдад хаагчдад тоон гарын үсгийн е-токен төхөөрөмжийг авсан. Одоогоор е-токен төхөөрөмжийг байцаагч ажилтнууд албан хэрэгцээнд бүрэн ашиглаагүй байна. /80/		Одоогоор е-токен төхөөрөмжийг албан хэрэг хөтлөлтөд ашиглаж байгаа бөгөөд бусад хэрэгцээнд бүрэн ашиглаагүй байна.
5.2.	№64	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад чиглэсэн төлөвлөгөөт хяналт шалгалтыг 50 хувиар бууруулах	Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн чиглэлийн дагуу гадагшаа чиглэсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлыг зогсоосон бөгөөд зөвхөн иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд аж ахуйн нэгж, байгууллагуудад “Нийгмийн даатгалын тухай” хуулийн хэрэгжилтийг шалгаж байна. /100/		

		2022.12.14 №64			
5.3.	№3	Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын 3, 4 дүгээр тунд хамрагдах... 2022.01.12 №3	Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын нийт албан хаагчдын 73,2% нь Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын 3, 3.1% хувь нь 4-р тунд тус тус хамрагдсан байна. /100/		
5.4.	№11	Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх... 2022.02.16 №11	<p>Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын ажил үйлчилгээг цахимжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ажил олгогчдод зориулсан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолтыг 2020 оноос эхлэн цахимжуулж, //nd8.ndaatgal.mn/onlineshim вэб сайтыг ашиглан авах боломжийг бүрдүүлэн ажиллаж, хэрэглээнд бүрэн нэвтрүүлсэн. - Ажил олгогч байгууллагын шимтгэлийн тайланг тоон гарын үсэг ашиглан цахимаар хүлээн авах ажлыг эрчимжүүлэн, мэдээлэл зөвлөгөө сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. - Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд нь тайлант хугацаанд нийт 6131 ажил олгогчийн тайланг тоон гарын үсэг ашиглан цахимаар хүлээн авч баталгаажуулан ажиллаж байна. - 2022 онд ажил олгогч руу чиглэсэн тоон гарын үсэг ашиглах сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж байна. <p>Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн архивын лавлагааг иргэдийг дүүрэг хооронд явуулахгүй, нийгмийн даатгалын хэлтэс хоорондоо цахимаар солилцож хэвшсэн. НДЕГ-ын даргын 2022 оны А/22 дугаар</p>		

		<p>тушаалыг үндэслэн нийгмийн даатгалын байгууллагаас олгож буй шимтгэл төлөлтийн лавлагааг үнэ төлбөргүй олгож байна. Ажил олгогч, иргэд даатгуулагчдад шимтгэл төлөлтийн болон бусад лавлагаа, тодорхойлолтыг үнэ төлбөргүй, цахимаар авах боломжийг бүрдүүлж, мэдээллээр ханган, холбогдох лавлагаа, тодорхойлолтыг E-Монголиа, ТҮЦ машин, гар утасны аппликейшн ашиглан авах талаар мэдээлэл сургалт, сурталчилгаа тогтмол өгч, 2006 оноос хойшхи QR код бүхий архивын лавлагааг заавар журмын дагуу харьялал харгалзахгүй, үнэ төлбөргүй, түргэн шуурхай гаргаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд НДЕГ-аас 2021 оныг “Эерэг хандлага-Цахим үйлчилгээний хөгжүүлэлтийн жил” болгон зарласан бөгөөд нийслэлийн байгууллагууд нь 2021.01.01-нээс эхлэн албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсгийн хэрэглээг бүрэн нэвтрүүлж, 2021 оноос одоог хүртэл тоон гарын үсгийн e-токен төхөөрөмжийг ашиглан албан бичиг боловсруулж, байгууллага хооронд QR код бүхий албан бичгийг хүргүүлэн ажиллаж байна. - “Эрх зүй, мэдээллийн технологийн шинэчлэл-80 жил”-ийн хүрээнд Нийгмийн даатгалын тэтгэмжийн үйлчилгээг цахимжуулж, иргэд даатгуулагчид тэтгэмжийн хүсэлтийг e-mongolia болон даатгуулагчийн вэбийг ашиглан цахимаар илгээх боломжийг бүрдүүлж ажилласан. - Нийслэлийн байгууллагуудын сангийн нягтлан бодогч, мэдээлэл технологийн мэргэжилтэн нар 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Сангийн яамнаас зохион байгуулсан “Шилэн дансны нэгдсэн цахим хуудас”-ыг ашиглах сургалтад хамрагдсан. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу шилэн дансны мэдээлэл оруулах www.shilendans.gov.mn сайт шинэчлэгдэж, шилэн дансны нэгдсэн цахим хуудас gar.mof.gov.mn вэб сайтыг 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс ашиглахаар шийдвэрлэсэн. Мэдээлэл технологийн мэргэжилтэн “Шилэн дансны нэгдсэн цахим хуудас”-нд https://gar.mof.gov.mn/ хэрэглэгчийн болон байгууллагын эрхийг үүсгэж, 		
--	--	--	--	--

			бүртгэл хийж ажилласан. Мөн шилэн дансны бүртгэлд хяналт тавих үйл ажиллагааг дотоод аудит, мониторинг хариуцсан мэргэжилтэн тусдаа эрх үүсгэж хэрэгжүүлэн ажилласан./100/		
5.5.	№16	МУ төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн худалдан авах явцын талаар 2022.03.16 №16	Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн худалдан авах төсөв Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудад тусгагдаагүй тул тендер шалгаруулалт зарлагдах арга хэмжээ болоогүй болно. /100/		
5.6.	№41	МУ Засгийн газрын хурлын тэмдэглэл 2022.08.17 №41	Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 сарын 13-ний өдрийн 52-р тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг танилцуулах богино хугацааны цахим сургалтыг Удирдлагын академийн мэргэшил дээшлүүлэх институт, Нийслэлийн засаг даргын тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төв хамтран үе шаттай зохион байгуулж байна. Үндэсний цахим шуудангийн системээр дамжуулан ирсэн өргөдөл гомдолыг хүлээн авч холбогдох албан тушаалтанд шилжүүлэн, хариу мэдээллийг шуудангаар болон албан бичгээр иргэнд хариу мэдээллийг хүргэн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг дагаж мөрдөн ажиллаж байна./100/		
5.7.	№46	МУ Засгийн газрын хурлын	Нийгмийн даатгалын тухай хууль болон 2022 онд шинээр хэрэгжих Монгол Улсын хууль-3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг -1, Монгол Улсын		

		тэмдэглэл 2022.09.22 №46	Ерөнхий сайдын албан даалгавар-1, Засгийн газрын тогтоол -12, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл -8, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал -5, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан даалгавар -1, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол -3, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал -15, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан даалгавар -1 -ийн шийдвэрийг гарсан хугацаанд албан хаагчдад танилцуулан хэрэгжүүлэн ажиллаж, холбогдох биелэлтийг гарган ажиллаж байна. Нийгмийн даатгалын тухай хууль, журмыг нэг мөр хэрэглэх байцаагч, ажилтны хууль зүйн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтад төрийн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагатай хамтран сургалт зохион байгуулсан ажиллаа. /100/		
5.8	№57	МУ Засгийн газрын хурлын тэмдэглэл 2022.09.22 №57	Тус газар нь хамт олны саналаар энэ жил “Шинэ жилийн баяр”-ын арга хэмжээг зохион байгуулж тэмдэглэхгүй болно. Мөн дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүд “Шинэ жилийн баяр”-ын арга хэмжээг зохион байгуулахдаа төсвийн хөрөнгө зарцуулаагүй болно. /100/		
Хэсгийн дундаж 97,5 хувь					
6. Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал					
6.1.	№А/191	Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам 2021.12.06 №А/191	2022 оны ээлжийн амралтын хуваарийг ажилтнуудын саналыг үндэслэн ажил, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байдлаар зохион байгуулж, газрын даргын /хэлтсийн дарга/ тушаалаар баталсан. Батлагдсан хуваарийн дагуу "Ээлжийн амралт олгох мэдэгдэл"-ийг холбогдох хэлтсийн дарга /нэгжийн дарга/ болон ажилтанд олгодог. 2021 оны 12 дугаар сарын 06-ний өдрийн А/191 тоот “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ыг бүх ажилтан, албан хаагчдад мэдээллийн цагаар сургалт зохион байгуулж ажилласан. /100/		
6.2.	№А/192	Дундаж цалин хөлс	2022 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөх Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын №А/192 дугаар тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна.		

		тодорхойлох журам 2021.12.06 №А/192	Дээрх журмын 1.2-т зааснаар “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр тэтгэмж, төлбөр тогтоон олгох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүн, дунджийг тодорхойлоход энэхүү журам хамаарахгүй” гэж заасан тул аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулсан сургалтад нягтлан бодогч нарт энэхүү журмыг танилцуулан ажиллаж байна. /100/		
6.3.	№А/193	Ажлын цагийг нэгтгэн бодох журам 2021.12.06 №А/193	Хөдөлмөрийн тухай хууль, /Шинэчилсэн найруулга/ Ажлын цагийг нэгтгэн бодох журмын дагуу албан хаагчдын ажлын цагийг ердийн ажлын цагаар баримтлан бодож, ажиллаж байна. Амралт баяр ёслолын өдрөөр ажилласан, илүү цагаар ажилласан ажилтан албан хаагчдад хөдөлмөрийн хуулийг баримтлан тооцон олгож байна. /100/		
6.4.	№А/32 А/246 А/81	Цаг уурын хүнд нөхцөлтэй гэж үзэх гадаад улсын жагсаалтыг шинэчлэн батлах тухай 2022.04.27 №А/32 А/246 А/81	Гадаад харилцааны сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын “Цаг уурын хүнд нөхцөлтэй гэж үзэх гадаад улсын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” хамтарсан тушаалыг нийт албан хаагчдад танилцуулан, мэдээлэл чиглэл өгч, хэрэгжүүлэн ажиллаж байна. /100/		
6.5.	№А/55	Туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай	Засгийн газрын 2022 оны А/55 дугаар тушаалаар батлагдсан гэрээний загвар болон нийгмийн даатгалын сайн дурын даатгалын ач холбогдолыг сурталчлан таниулах хамрах хүрээг нэмэгдүүлэх аливаа эрсдлийг хохирол багатай даван туулах, ирээдүйн нийгмийн хамгааллаа бүрдүүлэх, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр үйлчилгээ авах нөхцөлийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа. /100/		

		байгуулах хөдөлмөрийн гэрээний загвар батлах тухай 2022.03.29 №А/55			
Хэсгийн дундаж: 100 хувь					
7. Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан даалгавар					
7.1.	№03	Салбарын бодлого, төсвийн уялдааг сайжруулах тухай 2021.11.15 №03	Салбарын бодлого, төсвийн уялдааг сайжруулах тухай ХНХ-ын сайдын албан даалгаврын хүрээнд: 1. 2022 оны жилийн эцсийн байдлаар сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж 112,9 хувийн биелэлттэй ажиллаж, шинээр хамрагдсан ажил олгогчийн тоо 4508, сайн дурын болон албан журмын даатгуулагчийн тоог 47040 нэмэгдүүлэн ажилласан. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт болон байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг батлагдсан төсвийн хуваарийн дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. 2. Шилэн дансны хуулийн хүрээнд нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны үйл ажиллагааны урсгал зардлын төсөв, гүйцэтгэлийг хуулийн хугацаанд оруулж хэвшсэн. Нийгмийн даатгалын байгууллагын хүрээнд 3. Нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, улирал, хагас жилийн тайланг хугацаанд нь чанартай гаргаж хүргүүлсэн. /100/		
Хэсгийн дундаж: 100 хувь					
8. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол					

8.1	№20	Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай 2021.12.27 №20	Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн “Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай” 21 дүгээр тогтоолыг хэлтсийн вэб хуудаст байршуулан даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан тохиолдолд нэрийн дансны аргаар эсхүл 7 жилийн цалин хөлсний дунджаар тэтгэвэр тогтоолгох нөхцлүүдийн аль боломжтойг нь сонгох талаар зөвөлгөө мэдээлэл өгч ажиллаж байна. Тус тогтоолын дагуу иргэд, даатгуулагчдад тухай бүр цаг үеийн мэдээлэл, зөвлөгөөг хүргэн ажиллаж байна. /100/		
8.2	№21	Нэрийн дансны 2021 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай 2021.12.27 №21	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны “Нэрийн дансны 2021 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” 21 тоот тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Даатгуулагчдын ТДШНД-ны 2021 оны жилийн эцсийн байдлаарх үлдэгдлийн мэдээллийг нийгмийн даатгалын аппликейшн болон E-Mongolia, даатгуулагчдад зориулсан вэб системүүдэд байршуулсан мэдээллээр дамжуулж харах боломжтой талаар иргэд даатгуулагчдад мэдээллийг хүргэн ажиллаж байна. Мөн иргэн хүсэлт гаргасан тохиолдолд нэрийн дансны мэдээлэх хуудсыг хэвлэж өгч байна. /100/		
8.3	№04	Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2022.08.01 №04	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дагуу 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн оршуулгын тэтгэмжийн хэмжээ 2,0 сая төгрөг, амьгүй донор болж эс, эд эрхтэнээ бусдад шилжүүлсэн хүний /даатгуулагчийн/ ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг 3,5 сая төгрөг болгосныг хэрэгжүүлж ажиллана. /100/		
Хэсгийн дундаж: 100 хувь					
9. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал					
9.1.	№А/86	Журам батлах тухай	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/86 дугаар тушаалаар батлагдсан Нийгмийн даатгалын дотоод аудитын журмыг		

		2021.06.28 №А/86	нийт байцаагч, ажилтнуудад танилцуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Нийгмийн даатгалын байгууллага олон улсын стандартад нийцсэн дотоод аудитын тогтолцоог бий болгох зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгууллагын засаглал, хяналтын үйл явцыг шударгаар бодитой баталгаажуулалт хийж үнэн зөвөөр үнэлэх, эрсдэлийг тодорхойлох, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах зорилтын хүрээнд энэхүү журмыг ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна. /100/		
9.2.	№А/01	2022 оныг “Эрх зүй, мэдээллийн технологийн шинэчлэл-80 жил” болгон зарлах тухай 2022.01.03 №А/01	Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2022 оныг “Эрх зүй, мэдээллийн технологийн шинэчлэл-80 жил” зорилтот жил болгон зарласан зорилтот жилийн хүрээнд нийслэлийн иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомж, түүний ач холбогдлыг сурталчлах, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлэх зорилго дэвшүүлэн зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дээрх зорилтыг хэрэгжүүлснээр иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээг тохилог орчинд, шинэлэг хэлбэрээр, нэг цэгээс, шуурхай чирэгдэлгүй бүрэн авах боломж бүрдүүлэхээр төлөвлөгөө боловсруулан 2022.02.01 өдөр газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 21 ажил тусгагдаж хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэд даатгуулагчдад түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх нийгмийн даатгалын үйлчилгээг цахим сурталчилах QR Код бүхий Картыг хэвлэн тараах зэрэг ажлуудыг Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд хэрэгжүүлэн ажиллаж байна. /100/		
9.3.	№А/22	Тушаал хүчингүй болгох тухай 2022.02.12 №А/22	Энэхүү тушаалаар нийгмийн даатгалын байгууллагаас олгож буй шимтгэл төлөлтийн лавлагааг үнэ төлбөргүй байхаар шийдвэрлэсэн. Ажил олгогч, даатгуулагч иргэдийг мэдээллээр ханган холбогдох лавлагаа, тодорхойлолтыг Е-Монголиа болон ТҮЦ машинаас авах заавар, зөвлөгөөг өгч байна. “Архивын лавлагаа үнэгүй гаргах тухай”		

			<p>тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж архивын баримтыг үнэ төлбөргүй, түргэн шуурхай гарган үйлчилж байна.</p> <p>Энэ тушаал гарсантай холбогдуулан нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд Үнэт цаасны харилцах дансанд байсан 3 940 250 төгрөгийг НДЕГ-т төвлөрүүлсэн байна. /100/</p>		
9.4.	№А/17	<p>Заавар батлах тухай 2022.02.01 №А/17</p>	<p>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйл, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасныг үндэслэн нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн албан хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500000 /таван зуун мянган/ төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400000 /дөрвөн зуун мянган/ төгрөгөөр нэмэгдүүлсэн.</p> <p>Нийслэлийн хэмжээнд 200336 тэтгэвэр авагчийн тэтгэвэр сар 28,1 тэрбум төгрөгөөр буюу 2022 онд 309,1 тэрбум төгрөгөөр тэтгэврийн хэмжээ нэмэгдэж 2022 онд нийт тэтгэвэр авагчдад 1554,0 тэрбум төгрөгний тэтгэврийг цаг хугацаанд олгосон болно. /100/</p>		
9.5.	№А/31	<p>Журам батлах тухай 2022.02.24 №А/31</p>	<p>2022 оны 3, 4 сард НДЕГ-аас зохион байгуулсан тэтгэвэр, тэтгэмж тогтооход анхаарах асуудал, цахим тэтгэмжийн талаарх сургалтад нийт 230 гаруй албан хаагч хамрагдаж, дотооддоо сургалт зохион байгуулж, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаарх мэдээллийг нийт албан хаагчдад хүргэж, өдөр тутмын ажил үйлчилгээндээ хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2022 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн өөрчлөлт, НДЕГ-ын даргын 2022 оны А/31, А/72 тоот тушаалыг хэрэгжүүлэх, дээд байгууллагаас ирсэн журам чиглэлийг нийт байцаагч албан хаагчдад таниулах, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. /100/</p>		
9.6.	№А/72	<p>Журам батлах тухай</p>	<p>2022 оны 3, 4 сард НДЕГ-аас зохион байгуулсан тэтгэвэр, тэтгэмж тогтооход анхаарах асуудал, цахим тэтгэмжийн талаарх сургалтад нийт 230 гаруй албан хаагч хамрагдаж, дотооддоо сургалт зохион байгуулж,</p>		

		2022.04.27 №А/72	<p>нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаарх мэдээллийг нийт албан хаагчдад хүргэж, өдөр тутмын ажил үйлчилгээндээ хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2022 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн өөрчлөлт, НДЕГ-ын даргын 2022 оны А/31, А/72 тоот тушаалыг хэрэгжүүлэх, дээд байгууллагаас ирсэн журам чиглэлийг нийт байцаагч албан хаагчдад таниулах, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. /100/</p>		
9.7.	№А/87	Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай 2022.05.25 №А/87	<p>НДЕГ-ын даргын 2022 оны 05 сарын 25-ны өдрийн “Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” тушаалыг үндэслэн Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд газрын дарга болон хэлтсийн даргаараа батлуулсан тушаалаар хагас жилийн үндсэн хөрөнгийн тооллого хийж тооллогоор дутагдсан, илүүдсэн хөрөнгөгүй, хадгалалт хамгаалалт их бүрэн, шинээр хүлээн авсан хөрөнгүүдийг кодолж, ажилтнуудын эд хөрөнгийн картыг шинэчлэх ажлыг зохион байгуулан ажиллаа.</p> <p>Тус газрын 2021 оны үндсэн хөрөнгийн бүртгэлийг burtgel.pccsp.gov.mn програмд нэг бүрчлэн бүртгэж, биелэлтийг нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн ажилласан. /100/</p>		
9.8	№А/94	Аудитын зөвлөмж хэрэгжүүлэх тухай 2022.05.31 №А/94	<p>Нийслэл дэх төрийн аудитын газраас Нийслэлийн нийгмийн даатгалын газар болон дүүргүүдийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцсэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв шударга илэрхийлэгдсэн гэж “Зөрчилгүй” стандарт дүгнэлт авч ажилласан. Мөн 2021 оны санхүүгийн тайланд Нийслэл дэх Төрийн аудитын газрын захиалгаар ННДГ-т Мэдээлэл аудит ХХК, дүүргүүдэд 9 хувийн аудитын компаниуд аудит хийж, зөвлөмж ирүүлсэн бөгөөд уг зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг цаг хугацаанд нь гарган Нийслэл дэх аудитын газар болон НДЕГ-т хүргүүлэн ажилласан. /100/</p>		

9.9	№А/99	<p>Заавар батлах тухай 2022.06.15 №А/99</p>	<p>НДЕГ-ын даргын 2022 оны 06 сарын 15-ны өдрийн А/99 тоот тушаалын хэрэгжилтийг ханган Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль, Засгийн газрын 2022 оны 06 сарын 08-ны өдрийн 230 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад баримтлах журам”-ын дагуу 1000000 (нэг сая) ба түүнээс доош төгрөгийн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос албан журмын болон сайн дурын даатгуулагчийн өөрөө төлсөн 2022 оны 05-12 дугаар сарыг дуусталх хугацааны тэтгэврийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн 50 хувийг сар бүр буцаан олголтын олгож, холбогдох ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл хөтөлж, тайлагнан ажилласан. /90/</p>		<p>Зарим даатгуулагчийн дансны мэдээлэл зөрүүтэй, дансгүй гадаадад оршин сууж, амьдарч байгаа, өртэй байгууллага, овог, нэр регистрийн дугаар зөрүүтэй гэх зэргээс үүдэн буцаан олголт нь олгогдохгүй болон хугацаа хоцорч орж байна. Дансны мэдээлэл болон овог, нэр регистрийн дугаар зөрүүтэй байдлыг арилгахаар ажиллаж байна.</p>
9.10	№А/109	<p>Даатгуулагчийн төрлийн код</p>	<p>НДЕГ-ын 2022 оны 07 сарын 05-ны өдрийн А/109 тоот тушаалаар хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд ажил олгогчоос хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого олгосон эх (эцэг)-ийг бүртгэх даатгуулагчийн</p>		

		шинээр батлах тухай 2022.07.05 №А/109	төрөл кодыг “68” гэж тогтоон ажил олгогчийн болон даатгуулагчийн шимтгэл төлөх нийт хувь хэмжээ (24-26)-ээр төлүүлэхээр, цэргийн албан хаагч болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон боловч ажил хөдөлмөр эрхэлж байгаа цэргийн албан хаагчийг бүртгэх даатгуулагчийн төрөл кодыг “69” гэж тогтоон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг ажил олгогч болон даатгуулагчаас төлүүлэхгүй байхаар заасан. Уг тушаалаар батлагдсан даатгуулагчийн төрлийн кодын талаарх мэдээллийг аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодогчдоп хүргэн шимтгэл төлөлтийн тайлан авахдаа шалган баталгаажуулан ажиллаж байна. /100/		
9.11	A/132	Бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай 2022.09.02 №А/132	Тус газрын Ёс зүйн зөвлөл нь гомдол мэдээллийг хүлээн авч дүгнэлт гаргахдаа зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэн, Төрийн албаны тухай хууль болон Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн аль заалтыг зөрчсөн болох, ямар нотлох баримтаар тогтоогдож байгаа зэргийг нарийвчлан үзэж, ТАТХ-ийн аль зүйл заалтыг баримтлан ямар арга хэмжээ авахуулахаар санал болгож байгаа, ёс зүйн зөрчил биш болон хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй зэргийг нарийвчлан үзэж шийдвэрийг гаргаж байна. /100/		
9.12	A/145	Нийгмийн даатгалын салбарын хүүхэд хамгааллын бодлого батлах тухай 2022.10.03 №145	Хүүхэд гэр бүлийг аливаа эрсдэлд өртөх, эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зорилгоор тус газрын дэргэд Эцэг эхийн зөвлөлийг байгуулсан. Уг ажлын хүрээнд дараах ажлуудыг хийв. - Хүүхдийн гар утасны хэрэглээнд хяналт тавих талаар эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлж ажиллаа. - Бага насны хүүхэдтэй эцэг эхэд хүүхдээ сургууль, цэцэрлэгт хүргэж өгөх авах, эргүүлд гаргах боломжоор хангаж ажиллаж байна. - Сургуулиас зохион байгуулж байгаа олон нийтийн арга хэмжээнд эцэг эхчүүдийн оролцоо их байдаг тул байгууллагаас энэ тохиолдолд чөлөөг олгож байна. /100/		

9.13	A/155	<p>Журам батлах тухай 2022.10.14 №А/155</p>	<p>Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилах, иргэдэд нээлттэй, ил тод хүртээмжтэй үйлчилгээг хүргэх зорилгын хүрээнд тус хэлтэс нь НДЕГ-ын даргын 2022 оны А/155 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын фэйсбүүк хуудас ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Уг журамд заасан шаардлагын дагуу хэлтсийн пэйж хуудсыг хөгжүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулан, мэдээ мэдээллийг шинэчилж, тасралтгүй байдлыг ханган ажиллаж байна. /90/</p>		<p>Багахангай дүүргийн НДХ нь пэйж хуудсын хөгжүүлэлт хангалтгүй байна.</p>
9.14	A/152	<p>Аян зохион байгуулах тухай 2022.10.12 А/152</p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхийг газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2022 оны 10 дугаар сарын 12-ний өдрийн А/152 тоот тушаалаар 8 80 жил 8 бүтээлч ажил зохион байгуулах 8 заалт бүхий чиглэл ирүүлсэн чиглэлийн хүрээнд Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд дэд төлөвлөгөө гарган төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж ажилласан.</p> <p>Нийгмийн даатгалын байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойд “80 жил-8 бүтээлч ажил” аяны хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн ажилтнуудын хооронд ажлын байранд сэлгэн ажиллуулах, ажилтнуудын сайн туршлагыг хуваалцах, шинэ санаачилгыг түгээх, үйлчилгээний нэгдмэл стандартыг мөрдөх, нийгмийн даатгалын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 10 дугаар сарын 28-ны өдрийг дуусталх хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газрын ажилтнууд дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн ажлын байранд, Дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн ажилтнууд дүүрэг хооронд сэлгэн ажиллаж байна. Тус аянд НДЕГ, ННДГ, ДНДХ хэлтсийн 39 ажилтан албан хаагч нар хамрагдсан байна.</p> <p>“Байгаль эх дэлхийгээ хайрлая” уриан дор Туул голын эрэг орчим, усны нөөцийн сав газарт үүссэн хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагааг Нийслэлийн хот тохижилтын газартай хамтран зохион байгууллаа.</p>		

			<p>Энэхүү ажилд НДЕГ, ННДГ, Төвийн 6 дүүргийн нийт 350 гаруй албан хаагчид оролцож, 3 км газраас 600 орчим шуудай хог хаягдлыг цэвэрлэлээ.</p> <p>“Ид шид бүтээцгээе” уриан дор нэгдэж зорилтот бүлгийн хүүхдүүдэд сэтгэлийн дэм үзүүлэх, ирээдүй болсон бяцхан дүү нартаа инээд хөөр, баяр баясал, итгэл найдвар төрүүлж мэдлэгээр хөрөнгө оруулах ажлыг НДЕГ, ННДГ-ын ажилтан албан хаагч нарыг хамруулан 2022 оны 10 дугаар сарын 23-28-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав.</p> <p>Энэхүү аяны хүрээнд ажилтан албан хаагч нар нийт 400 гаруй ном, сурах бичиг, найман нэр төрлийн 150 гаруй хичээлийн хэрэгсэл, 80 орчим тоглоомыг цуглуулж Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг “Хүүхдийн Оюуны боловсролыг дэмжих төв НҮТББ”-д хүлээлгэн өгөв.</p> <p>Тус номын сан нь Чингэлтэй дүүргийн 17, 18 хорооны 5000 гаруй хүүхэд ая тухтай таатай орчинд чөлөөт цагаа өнгөрөөн, хараа хяналтгүй байдлаасаа болж төрөл бүрийн осол, гэмт хэрэгт өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, номын сангийн хөтөлбөрүүдээр дамжуулан хичээлийн хоцрогдлоо арилгах, авьяас чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх боломжийг бүрдүүлж, 2009 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хүүхдүүдээс гадна насанд хүрэгчдэд зориулсан нэмэлт хөтөлбөрүүд боловсруулж, иргэдийн мэдлэг мэдээллийн тэгш хүртэх боломжийг хангахад хувь нэмэр оруулах, аж амьдралаа дээшлүүлэхэд тус дэм болох, өөр хоорондоо туршлага солилцох, хамтдаа хөгжих орон зайг бий болгодог байна. /100/</p>		
9.15	A/154	Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах тухай 2022.10.14 A/154	Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/27 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтын журам”-ын дагуу нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалт 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 2022 оны 11 сарын 21 хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулагдлаа.		

			Нийслэлийн хэмжээнд 191, Орон нутагт 252 байцаагч албан хаагчид хамрагдаж ерөнхий мэдлэгийн сорил, онол аргазүйн бодлого, Монгол бичиг, албан хэрэг хөтлөлт гэсэн 3 чиглэлээр шалгуулж мэдлэг чадвараа сорин өрсөлдлөө. /100/		
Хэсгийн дундаж: 98,6 хувь					
10. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан даалгавар					
10.1.	№01	<p>Ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар авах арга хэмжээний тухай</p> <p>2022.01.25 №01</p>	<p>Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр шинэчлэн байгуулсан бөгөөд Тамгын хэлтсээс 2, Хяналт шалгалт дотоод аудитын хэлтсээс 3, Санхүү бүртгэлийн хэлтсээс 1 албан хаагчийн төлөөлөл оролцон хамт олны саналыг үндэслэн ёс зүйн хороог шинэчлэн байгууллаа. Тус газрын ёс зүйн зөвлөлийн гишүүд Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 2022 онд ёс зүйн чиглэлээр 4 удаагийн сургалтуудад хамрагдсан. Журамд заасны дагуу ёс зүйн зөрчлийн мэдээг хагас бүтэн жилээр НЗДТГазарт Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж байна.</p> <p>Тус газрын ёс зүйн зөвлөл дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой 4 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэснээс 2 асуудлыг Хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэх үндэслэлээр, 2 асуудлыг Уучлал гуйхыг үүрэг болгох тогтоол гаргасан. Шинээр байгуулагдсан ёс зүйн зөвлөл нь ёс зүйн хороогоор шийдвэрлэгдсэн зөрчлийн байдалд дүгнэлт хийж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, зохион байгуулахдаа ёс зүйн хорооны дарга гишүүдэд Ёс зүйн тухай ойлголт, ёс зүйн зөрчлийг бусад, ялангуяа сахилгын зөрчлөөс ялгаж зааглах чиглэлээр системтэй сургалт зохион байгуулах шаардлагатай гэж үзлээ.</p> <p>Төрийн албаны болон нийгмийн даатгалын ажилтны ёс зүй, сахилга батыг чанд сахиж, ажлын хариуцлага, цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулж, үүрэгт ажлаа санаачилгатай, үр дүнтэй гүйцэтгэж байна.</p>		

			Хэлтсийн болон тасгийн дарга нар ажил үйлчилгээнд батлагдсан хуваарийн дагуу өдөр бүр хяналт тавьж, байцаагч ажилтнуудыг чиглүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, иргэд даатгуулагчдыг хүлээн авч уулзаж, ажлын байрны стандарт, дэг журмыг мөрдөн ажиллаж байна. /100/		
Хэсгийн дундаж: 100 хувь					
11. Нийслэлийн нийгмийн даатгалын газрын тушаал					
11.1.	№А/05	Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай 2022.01.13 №А/05	Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын даргын 2022 оны Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/05 дугаар тушаалын хэрэгжилтийг заалт тус бүрээр 100 хувь биелүүлэн ажилласан болно. /90/		
11.2.	№2/133	Зөрчил арилгах тухай 2022.05.05 №2/133	Нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн харилцах дансны орлогыг 7 хоног болон сарын сүүлийн өдрүүдэд бүрэн хуваарилах, төв санд төвлөрүүлэх, сарын зарлагын дүнгээр мөнгөн хөрөнгийг үлдээх тал дээр ажлаа зохион байгуулж харилцагч арилжааны банкуудад албан тоот хүргүүлэн зөрчил гаргахгүйгээр ажилласан. /90/		
11.3.	№1/132	Зөрчил арилгах тухай 2022.05.05 №1/132	Нийслэлийн нийгмийн даатгалын газрын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 1/132 тоот албан бичиг Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2016 оны “Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн урсгалыг зохицуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/51, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2019 оны “тушаалд өөрчлөлт оруулах тухай” А/121 дугаартай тушаалаар орлогын төвлөрсөн харилцах дансны үлдэгдлийг 7 хоног болгон сарын зарлагын дүнтэй тэнцэх мөнгөн хөрөнгийг данснуудад үлдээн, үлдэгдэл мөнгөн хөрөнгийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт төвлөрүүлэх үүргийн дагуу дараах ажлуудыг зохион байгууллаа. Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангийн 79,623,764.7 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн 5,645,344.8 төгрөг, ҮОМШӨ-н даатгалын		

			сангийн 18,813,864.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн 51,817,461.0 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангийн 120,768.8 мянган төгрөг, бүгд 156,021,203.6 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлэн ажилласан болно. /90/		
Хэсгийн дундаж: 90 хувь					
Нийт дундаж: 97,4 хувь					

ХЯНАЖ ТАНИЛЦСАН: ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

О.БАЙГАЛМАА

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭЖ ТАЙЛАГНАСАН:

БОДЛОГЫН ХЭРГЭЖИЛТ,

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.СОЛОНГО